



“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ  
ХУВЬЦААТ КОМПАНИД

## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.05.30 № 03/4501  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан МИАТ/20240102008 дугаартай “Зорчигч үйлчилгээний нэг удаагийн цаасан хэрэглэл” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтын 1, 2, 3 дугаар багцад оролцсон “Очирпресс” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Очирпресс” ХХК-ийн ирүүлсэн гомдолд тендер шалгаруулалтын 1 дүгээр багцад хүргүүлсэн загвар дээжийг үндэслэж тендерээс татгалзсан нь үндэслэлгүй, дотоодын үйлдвэрийн бараанд давуу эрх олгох заалтыг баримтлаагүй, тендер шалгаруулалтын 1 болон 3 дугаар багцад шалгаруулсан “Грандавто ланд” ХХК нь гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэх, сүүлийн 3 жилд ижил төстэй гэрээ хэрэгжүүлсэн эсэх, загвар болгож ирүүлсэн дээж нь техникийн үзүүлэлттэй нийцэж буй эсэхийг шалгуулах, мөн “Грандавто ланд” ХХК сүүлийн 3 жилд ижил төстэй гэрээ хэрэгжүүлсэн байх магадлал бага тул үнэлгээний хороотой үгсэн хуйвалдсан байж магадгүй тул шалгаж өгөхийг хүссэн байна.

I. Гомдолд дурдсаны дагуу тендер шалгаруулалтын 1 дүгээр багцад ирүүлсэн “Очирпресс” ХХК-ийн тендерийг хянан үзлээ.

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 17.4-т “Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: Тийм. Санал болгож буй бараа бүтээгдэхүүний төрөл тус бүр дээр техникийн тодорхойлолтод заасан хэмжээ, загвар, өнгөөр дээж ирүүлнэ. /Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагчийн хаягаар битүүмжлэн авчрах шаардлагатай/. “МИАТ” ТӨХК-ийн үйлчилгээнд явж буй бараа бүтээгдэхүүний загвар, дээж ирүүлсэн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. Логотой бараа бүтээгдэхүүний хувьд загвар дээж дээр логог наамал эсхүл хатгамал хэлбэрээр ирүүлж болох бөгөөд шалгарсан тохиолдолд логог техникийн тодорхойлолтод зааснаар нийлүүлнэ.” гэж заасан байна.

“Очирпресс” ХХК техникийн тодорхойлолтын харьцуулсан хүснэгтэд цаасан аяганы өндөр 85мм гэж ирүүлсэн байна.

9766007929

Үнэлгээний хорооны 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хурлын тэмдэглэлд “Очирпресс” ХХК-ийн ирүүлсэн загвар дээжийг шалгахад аяганы өндөр тендер шалгаруулалтын баримт бичгийн техникийн тодорхойлолтод зааснаас зөрүүтэй талаар дурдсан байх бөгөөд захиалагчаас ирүүлсэн загвар, дээжийн зурагт аяганы өндөр 80мм байх тул шаардлага хангаагүй гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

2. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Захиалагч шаардлагад нийцсэн тендерийг энэ хуулийн 11.4-т заасан үнэлгээний үндсэн шалгуурын дагуу үнэлнэ.” гэж заасан.

Захиалагч “Очирпресс” ХХК-ийн ирүүлсэн тендерийг шаардлагад нийцсэн тендер ирүүлсэн гэж үнэлээгүй тул давуу эрх тооцоогүй захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

II. Гомдолд дурдсаны дагуу тендер шалгаруулалтын 1 дүгээр багцад захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Грандавто ланд” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д “Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: Шаардлагатай” гэж, мөн ТШЗ 20.1-д “Оролцогчийн туршлагыг харуулах Өгөгдлийн хүснэгтэд заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн гэрээний талаар V бүлгийн Маягт 3, Маягт 5-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл; Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилийн туршлагын мэдээлэл, гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлнэ” гэж тус тус заасны дагуу “Грандавто ланд” ХХК 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 13/24 тоот албан бичгээр ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл, ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлснийг шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

2. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 17.4-т “Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: Тийм. Санал болгож буй бараа бүтээгдэхүүний төрөл тус бүр дээр техникийн тодорхойлолтод заасан хэмжээ, загвар, өнгөөр дээж ирүүлнэ. /Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагчийн хаягаар битүүмжлэн авчрах шаардлагатай/. “МИАТ” ТӨХК-ийн үйлчилгээнд явж буй бараа бүтээгдэхүүний загвар, дээж ирүүлсэн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. Логотой бараа бүтээгдэхүүний хувьд загвар дээж дээр логог наамал эсхүл хатгамал хэлбэрээр ирүүлж болох бөгөөд шалгарсан тохиолдолд логог техникийн тодорхойлолтод зааснаар нийлүүлнэ.” гэж заасан байна.

Үнэлгээний хорооны 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хурлын тэмдэглэлд “Грандавто ланд” ХХК-ийн ирүүлсэн загвар, дээжид үнэлгээ хийж шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн техникийн тодорхойлолтод “Холбогдох сертификат: Эрүүл ахуйн шаардлага хангасан байх ба “Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ” эсвэл Үндэсний итгэмжлэлийн төвийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг ирүүлнэ.” гэж заасны дагуу “Грандавто ланд” ХХК тендерт Стандарт, хэмжил зүйн газрын УБИ849 дугаартай тохирлын

гэрчилгээ ирүүлснийг шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

III. Гомдолд дурдсаны дагуу тендер шалгаруулалтын 3 дугаар багцад захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Грандавто ланд” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д “Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: Шаардлагатай” гэж, мөн ТШЗ 20.1-д “Оролцогчийн туршлагыг харуулах Өгөгдлийн хүснэгтэд заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн гэрээний талаар V бүлгийн Маягт 3, Маягт 5-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл;

Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилийн туршлагын мэдээлэл, гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлнэ” гэж тус тус заасны дагуу “Грандавто ланд” ХХК 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 13/24 тоот албан бичгээр ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл, ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлснийг шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

2. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 17.4-т “Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: Тийм. Санал болгож буй бараа бүтээгдэхүүний төрөл тус бүр дээр техникийн тодорхойлолтод заасан хэмжээ, загвар, өнгөөр дээж ирүүлнэ. /Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагчийн хаягаар битүүмжлэн авчрах шаардлагатай/. “МИАТ” ТӨХК-ийн үйлчилгээнд явж буй бараа бүтээгдэхүүний загвар, дээж ирүүлсэн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. Логотой бараа бүтээгдэхүүний хувьд загвар дээж дээр логог наамал эсхүл хатгамал хэлбэрээр ирүүлж болох бөгөөд шалгарсан тохиолдолд логог техникийн тодорхойлолтод зааснаар нийлүүлнэ.” гэж заасан байна.

Захиалагч дээрх тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар сонирхогч этгээдээс ирүүлсэн хүсэлтийн хариуд “Цаасан наалтын материал PET, жин 226.8 грамм, хэмжээ 5.5\*9см байна. 70-100 хуудас нь хоорондоо цавуугаар наалдаж бэхлэгдсэн байх бөгөөд цавууны түрхлэг зөвхөн дээд хэсэгт байна” гэж худалдан авах ажиллагааны цахим системд тодруулга нийтэлсэн байна.

Үнэлгээний хорооны 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хурлын тэмдэглэлд “Грандавто ланд” ХХК-ийн ирүүлсэн загвар, дээжийг үнэлж тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бүх шаардлагад нийцсэн, цаасан толгойвчийн хувьд “FAR 25” сертификат шаардсаныг ирүүлсэн гэж дурдсан байх тул шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

Түүнчлэн захиалагч байгууллагаас ирүүлсэн материалд “Грандавто ланд” ХХК-ийн ирүүлсэн загвар, дээжийг үнэлээд “МИАТ” ХК-ийн үйлчилгээнд ашиглаж байгаа бүтээгдэхүүний загвар ирүүлсэн талаар дурдаагүй байх тул “МИАТ” ХК-ийн үйлчилгээнд ашиглаж байгаа бүтээгдэхүүнийг загвар болгон ирүүлсэн эсэх гэх гомдол үндэслэлгүй байна.

3. Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт зөөлөвч, цаасан толгойвч, цаасан наалттай холбоотой ижил төстэй гэрээ хэрэгжүүлсэн байх шаардлага заагаагүй тул “Грандавто ланд” ХХК зөөлөвч, цаасан толгойвч, цаасан

наалттай холбоотой ижил төрлийн гэрээ хэрэгжүүлсэн эсэх гэх гомдол үндэслэлгүй байна.

IV. Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын 4.3-т “Хуулийн 28.1.3-т заасан шийдвэрийг эс зөвшөөрөх тухай гомдолд захиалагч тус оролцогчийн тендерээс татгалзсан аль нэг үндэслэлийг хүлээн зөвшөөрсөн, эсхүл эс зөвшөөрөх тухай үндэслэл, тайлбар ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзсан шийдвэрийг хэсэгчлэн хүлээн зөвшөөрсөн гэж үзэж гомдлыг хуулийн 59.3-т заасныг хангахгүй гэж үзнэ” гэж заасан.

“Очирпресс” ХХК дээрх тендер шалгаруулалтын 2 болон 3 дугаар багцтай холбогдуулан тус компанийн тендерээс татгалзсан үндэслэлийг эс зөвшөөрөх тухай тайлбар ирүүлээгүй тул дээрх журмын 4.6-д “Сангийн яам энэ журмын 4.1, 4.2, 4.3, 4.4, 4.5-д заасныг зөрчсөн гомдлыг хуулийн 59.5-д заасныг үндэслэн хүлээн авахаас татгалзаж буцаана” гэж заасны дагуу тус компанийн тендерээс татгалзсан захиалагчийн шийдвэртэй холбоотой асуудлыг хянан үзээгүй болно.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: “Очирпресс” ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ